



# СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

№131 /345/

2022.07.28

Цаг үе, үйл явдал

## МОНГОЛЫН ХӨХ ТЭНГЭРТ СӨНӨӨГЧ ОНГОЦНЫ ДУУ ДАХИН ЦУУРАЙТЛАА



Монгол Улсын Зэвсэгт хүчний Агаарын цэргийн алба хаагчид МиГ-29УБ загварын сургууль, байлдааны сөнөөгч онгоцоор бие даасан анхны шалгах нислэгээ өчигдөр амжилттай гүйцэтгэлээ. Тус үйл ажиллагаанд Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлагч хурандаа Т.Ганбат, штабын дарга бригадын генерал Б.Эрдэнэбат, бэлтгэл хошууч генерал О.Энхбаяр болон албаны бусад

хүмүүс, ахмад нисгэгчид оролцлоо. Тус сөнөөгч онгоцны нисгэгчид нь ОХУ-ын Краснодар хотын Нисэхийн их сургуулийг 2011 төгссөн юм. Энэ жил тэд тус Нисэхийн их сургуульд шилжин суралцаж, нисгэгчдийн ур чадвар, инженер техникийн ажилтнуудын онол, дадлагын сургалт бэлтгэлийг бүрэн хангаж, ийнхүү анх удаагаа монгол цэргүүд МиГ-29УБ онгоцыг

хөх тэнгэрт хөөргөж чаджээ.

БНМАУ-ын Батлан хамгаалах яамны сайдын 1970 оны 9 дүгээр сарын 23-ны өдрийн тушаалаар МАА-ын анхны сөнөөгч онгоцны эскадрилийг байгуулах шийдвэр гарч, фронтын амдан сөнөөгч "МиГ-17", "МиГ-15УТИ", "МиГ-21ФПМ", "МиГ-21УМ" нислэг үйлдэж байгаад 1993 оноос хойш Монголын хөх тэнгэрт сөнөөгч онгоцны дуу цуурайтаагүй юм.

Сургууль, байлдааны "МиГ-29УБ" сөнөөгч онгоцыг манай орны Зэвсэгт хүчин зэвсэглэлдээ авч, нислэг үйлдэж эхэлснээр улсын агаарын хилийн орон зайн аюулгүй байдлыг сахих, улсын болон цэргийн онц чухал объектыг агаарын болзошгүй халдлагаас халхлах, агаарын дайсныг алсын нөхцөлд устгах боломжтой юм.



## ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААГ СУРТАЛЧЛАХ ӨДӨРЛӨГӨӨР ...



### Зэвсэгт хүчний 234 дүгээр анги

Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч бригадын генерал Ж.Болдбаатараар ахлуулсан ажлын хэсгийнхэн Булган аймагт ажиллаж, батлан хамгаалах бодлого, зорилт, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг сурталчилж, орон нутгийн удирдлагуудтай цаашдын хамтын ажиллагаагаа тодотголоо. Арга хэмжээнд Зэвсэгт хүчний Кибер аюулгүй байдлын цэргийн командлагч бригадын генерал Д.Баасандамба, Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн захирал бригадын генерал П.Жаргалан, Зэвсэгт хүчний 234 дүгээр ангийн захирагч хурандаа Г.Эрдэнэбаяр, Булган аймгийн Засаг дарга Б.Ариун-Эрдэнэ нарын албаныхан оролцов.

Тэд цэрэг-эх оронч үзэл



төлөвшлийн талаар залуучуудад лекц уншиж, Цогт хунтайжийн хөшөөнд цэцэг өргөлөө.

Мөн энэ үеэр аймгийн төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын авьяаслаг алба хаагчид цэрэг-эх орны сэдэвт урлагийн тоглолтыг олон нийтэд толилуулаа.

Дэслэгч Ч.ОЮУНЧИМЭГ

### ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 17	🌧️ 07


ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 31	🌧️ 23

### ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3.183.00	3.190.0
EUR 🇪🇺	3.242.0	3.260.0
CNY 🇨🇳	472.50	474.00
RUB 🇷🇺	50.80	51.50
JPY 🇯🇵	23.00	23.20
KRW 🇰🇷	2.39	2.41

### ЗУРХАЙ



2022.07.28 /ПҮРЭВ ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 30

### ЗУНЫ ДУНД УЛААН МОРЬ САРЫН НЭГ ЦАГААН МЭНГЭТЭЙ ХАР МОРЬ ӨДӨР

**Үс засуулбал:**  
**Эрлэг лугаа учирна**  
**НАРАН УРГАХ, ШИНГЭХ:**  
**05.23-20.34**  
**Барилдлага:**  
**Хүчин төгсөх**  
**Шүтэн барилдлага:**  
**Хуран үйлдэхүй**  
**Суудал: Мод**

Энэ өдөр бар жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр буян номын үйлийг эхлэх, дээдсээс халамж хүсэх, лам хувраг болох, багш шавьд барилдах, номын абшиг авах, шинэ гэр ба байр авах, угаал үйлдэх, тангараг тавих, гэр бүрэхэд сайн. Хэрүүл тэмцэл хийх, хүүхэд хөлд оруулахад муу.

Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой. Хол газар яваар одогсод хойшоо мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй..

### КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 577,999,660

Эдгэрсэн

Нийт: 547,749,996

Нас барсан

Нийт: 6,409,799

# МОНГОЛЫН ХӨХ ТЭНГЭРТ СӨНӨӨГЧ ОНГОЦНЫ ДУУ ДАХИН ЦУУРАЙТЛАА



## НЭГТГЭЛИЙНХЭН 30 КМ ЯВГАН МАРШ ҮЙЛДЭВ



**Зэвсэгт хүчний  
016 дугаар нэгтгэл**  
Нэгтгэлийн 2021-2022  
оны сургуулийн жилийн  
сургалтын төлөвлөгөөний  
дагуу бие бүрэлдэхүүнтэй

явуулах “Тактик, тусгай  
бэлтгэлийн цогцолбор” 30  
километрийн явган маршийг  
5 цэгээр амжилттай зохион  
байгууллаа. Явган маршийг  
уулархаг болон ой модтой

газар оронд “Мотобуудлагын  
салаа, тасаг” давших, үүрэг  
гүйцэтгэхдасгалууд, тактикийн  
бэлтгэлийн нормативуудыг  
боловсруулсан нь онцлог  
байлаа.

Хошууч  
Д.ДОЛГОРЖАВ



## ФОТО АГШИН

## ТОРГОН ЦЭРГҮҮД ТӨРИЙН ТАХИЛГЫН ЁСЛОЛД...

Увс аймгийн Өндөрхангай, Цагаанхайрхан сумдын нутагт орших Хан Хөхий уулын тэнгэрийг тайх төрийн тахилгын ёслол 2022 оны 7 дугаар сарын 27-ны өдөр болов. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2007 оны 7 дугаар сарын 26-ны өдрийн 183 дугаар зарлигаар Хан Хөхий уулыг Төрийн тахилгатай болгосон байна.

Үүнээс хойш 2008, 2012, 2017 онуудад тус тус Хан Хөхий уулын тэнгэрийг тайх төрийн тахилгын ёслолыг зохион байгуулж байжээ.



Дарга, ерөнхий  
редактор, хурандаа  
САНЖМЯТАВЫН  
ТӨМӨРХҮЯГ



ЦАХИМ ХАЯГ



Батлан хамгаалах яам



Зэвсэгт хүчний  
Жанжин штаб



ЦАХИМ ХУУДАС



“Соёмбо” сонин



“Дуулга” студи

\* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.

\* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.

\* Тус сонины мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон  
Индекс: 10018

Цахим шуудан:  
Soyombo@mod.gov.mn  
Утас: 70001029, 3412 (дотуур)